



Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар

САНХҮҮГИЙН АУДИТЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СБА-2024/01/НА-СТА-ТЕЗ

Баруун-Урт сум 2024 он



Дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Аудитын менежер М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Н.Болдбаатар

Утас: 70512127 Цахим хаяг: Boldbaatar@audit.gov.mn

Аудитор Б.Мөнхбамбар

Утас: 70512127 Цахим хаяг: Munkhbambar@audit.gov.mn

Агуулга

Contents

| | |
|--|-----------|
| товчилсон үгийн жагсаалт | 2 |
| ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ | 2 |
| 1. Аудитын гэрчилгээ | 3 |
| 2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан | 5 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан | 5 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан | 5 |
| 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 6 |
| 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/ | 7 |
| 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 8 |
| 2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан | 9 |
| 5. АУДИТЫН ЗӨВЛӨМЖ | 10 |
| 5.2. Үндэсний аудитын газарт санал:..... | 10 |



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|----------|---|
| ААНОАТ | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| АТӨЯХАТ | Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар |
| ЗДНХ | Засаг даргын нөөц хөрөнгө |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| НББОУС | Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ОНӨГ | Орон нутгийн өмчийн газар |
| ОНХНС | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| СТСХ | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| ТӨҮГ | Төрийн өмчит үйлдвэрийн газар |
| УИХ | Улсын Их Хурал |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Стандарт |
| УТХО | Улсын төсвийн хөрөнгө оруулалт |
| ҮТП | Үйлдвэр технологийн парк |
| ХХК | Хувьцаат хязгаарлагдмал компани |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

| | |
|--------------|---|
| Хүснэгт №1 | Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл |
| Хүснэгт №2 | Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл данс бүрээр |
| Хүснэгт №3 | Авлагын үлдэгдэл |
| Хүснэгт №4 | Хоршоо хөгжүүлэх сангийн авлага |
| Хүснэгт №5 | Бараа материалын үлдэгдэл |
| Хүснэгт №6 | Улсын нөөцөөс олгосон бараа жагсаалт |
| Хүснэгт №7 | Урьдчилгаа дансны үлдэгдэл |
| Хүснэгт № 8 | Үндсэн хөрөнгийн үлдэгдэл |
| Хүснэгт № 9 | Нийт өр төлбөрийн үлдэгдэл |
| Хүснэгт № 10 | Засгийн газрын оролцоо |
| Хүснэгт №11 | Төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл |
| Хүснэгт№12 | Зардлын бүртгэл |
| Хүснэгт№13 | Сөрөг дүгнэлт өгсөн байгууллага |
| Хүснэгт№14 | Төсвийн шууд захирагчийн зөрчлийн судалгаа |
| Хүснэгт№15 | Төсвийн төвлөрүүлэн захирагчийн зөрчлийн судалгаа |
| Хүснэгт№16 | ОНӨААТҮГ-ын зөрчлийн судалгаа |
| Хүснэгт 17 | Өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт |

1. Аудитын гэрчилгээ



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА М.ИДЭРБАТ ТАНАА

2024.04.25 № 310
танай _____ - ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сүхбаатар аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Сүхбаатар аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар материаллаг шинжтэй 1,107.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн. Энэ нь хандив тусламжийн орлогыг төсвийн бүрэлдэхүүн хэсэгт төлөвлөөгүй төсвөөс гадуур зарцуулж, бүртгэл тайланд тусгаагүй, хөрөнгө данс бүртгэлд бүртгээгүй, өр төлбөрийг болзошгүй байдлаар толилуулсан зэрэг нь Төсвийн тухай хууль, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 08 дугаар тогтоолоор орон нутгийн өмчит бүртгэлтэй 11 эмийн эргэлтийн санг хувийн хэвшилд шилжүүлж, тайлант оны нэгтгэлээс хасагдсан байна.

D:/Bichig hereg/2024/A4 toot

Аудитын гол асуудал

Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагаас авах ирэх оны татварын бус орлогыг урьдчилан авч төсвийн зарлагыг санхүүжүүлж, бүртгэлээр алдаатай тайлагнасан.

Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 сарын 04 өдрийн 02 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө, биелэлтийн тайланг хэлэлцэж нийт төлөөлөгчдийн 84.6 хувийн саналаар "Хангалттай" гэж үнэлжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

D:/Bichig hereg/2024/A4 toot

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|-----------|--|----------------|-----------------------|------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 34,801,911.20 | 49,816,470.30 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 3а, 3б | 14,816,996.80 | 24,731,428.10 |
| 33 | АВЛАГА | 5а, 5б, 6а, 6б | 5,108,126.50 | 4,939,872.10 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 7а, 7б | 384,661.70 | 35,289.50 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 8а, 8б, 8в | 3,375,560.00 | 3,482,021.10 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 9а | 48,377.00 | 83,833.60 |
| 360 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 10 | 11,068,189.20 | 16,544,025.90 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 63,259,470.50 | 73,051,893.10 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 12а, 12б, 12в | 63,259,470.50 | 73,051,893.10 |
| 39200 | Биет хөрөнгө | | 58,238,088.40 | 64,191,091.20 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 13 | 5,013,496.80 | 8,852,106.90 |
| 39400 | Бусад хөрөнгө /ТӨҮГ/ | 14 | 7,885.30 | 8,695.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | | 98,061,381.70 | 122,868,363.40 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 28,615,821.20 | 36,147,211.20 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 15а, 15б | 20,865,899.00 | 23,332,671.40 |
| 41200 | Богино хугацаат зээлийн өглөг | 16а, 16б | 884,284.10 | 663,250.90 |
| 41300 | Өглөг | 17а, 17б | 1,435,415.40 | 1,668,401.40 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 18а, 18б | 18,546,199.50 | 21,001,019.10 |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 7,749,922.20 | 12,814,539.80 |
| 42200 | Урт хугацаат зээл | 20а, 20б | 7,749,922.20 | 12,814,539.80 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 69,445,560.50 | 86,721,152.20 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | | 69,445,560.50 | 86,721,152.20 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | | 33,043,809.80 | 34,606,863.20 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | | 1,007,311.90 | 2,955,971.60 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | | 236,956.00 | 236,956.00 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | | 25,083,731.00 | 38,848,461.90 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 10,073,751.90 | 10,072,899.60 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | | 98,061,381.70 | 122,868,363.40 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|-----------|---|---------------|-----------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | | 91,984,571.90 | 116,066,018.60 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | | 24,116,122.00 | 32,436,542.40 |
| 110 | Орлогын албан татвар | | 18,256,015.70 | 26,783,154.10 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | | 9,068,977.80 | 12,300,245.60 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | | -450,203.30 | -581,981.30 |
| 1103 | ААН-ын орлогын албан татвар | | 9,637,241.30 | 15,064,889.90 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | | 2,385,775.10 | 2,290,998.00 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | | 3,474,331.20 | 3,362,390.30 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1а, 1б | 44,918,400.60 | 52,100,304.70 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 26,390,879.20 | 25,236,387.10 |

| | | | | |
|------|--|---------------|-----------------------|----------------------|
| 121 | Хөрөнгийн орлого | | 0 | 103,876.60 |
| 122 | Тусламжийн орлого | | 4,200.00 | 0 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | | 18,523,321.40 | 26,760,041.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 22,950,049.40 | 31,529,171.50 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2а, 2б | 63,989,350.90 | 85,037,315.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 63,273,873.00 | 84,170,127.30 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 61,906,846.20 | 83,221,876.10 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 8,770,969.80 | 11,625,006.80 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 1,088,054.90 | 1,417,366.60 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 5,878,497.40 | 898,226.90 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 21,606,356.60 | 30,621,991.20 |
| 2105 | Нормативт зардал | | 349,175.00 | 12,617.70 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 1,202,145.60 | 502,861.70 |
| 2107 | Томилполт, зочны зардал | | 245,062.60 | 346,277.90 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 10,764,502.40 | 17,609,076.60 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 12,002,082.10 | 20,188,450.60 |
| 212 | ТАТААС | | 330,000.00 | 70,496.90 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 1,037,026.90 | 877,754.40 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 715,477.80 | 867,187.60 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | | 27,995,221.10 | 31,028,703.60 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | | 2,090.90 | 0 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 85,490,301.20 | 22,190,469.80 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | | -57,492,989.20 | 8,838,233.80 |

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөг/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|------|---|---|-----------------------|------------------------|
| 1 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 125,038,759.50 | 0 | 125,038,759.50 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 1,908,973.90 | 0 | 1,908,973.90 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 126,947,733.40 | 0 | 126,947,733.40 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -20,803.70 | 0 | -20,803.70 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0 | 0 | 0 |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0 | 0 | 0 |
| 7 | Өмчид гарсан өөрчилөлт | 11,620.00 | 0 | 11,620.00 |
| 8 | Зарласан ногдол ашиг | 0 | 0 | 0 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | -57,492,989.20 | 0 | -57,492,989.20 |
| 10 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 69,445,560.50 | 0 | 69,445,560.50 |
| 11 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 69,445,560.50 | 0 | 69,445,560.50 |

| | | | | |
|-----------|---|----------------------|----------|----------------------|
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 4,648,928.60 | 0 | 4,648,928.60 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 74,094,489.10 | 0 | 74,094,489.10 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -852.2 | 0 | -852.2 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0 | 0 | 0 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0 | 0 | 0 |
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт | 3,789,281.60 | 0 | 3,789,281.60 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0 | 0 | 0 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 8,838,233.80 | 0 | 8,838,233.80 |
| 20 | 2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 86,721,152.20 | 0 | 86,721,152.20 |

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|------------|--|-----------|-----------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | | 94,161,721.80 | 118,507,753.40 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | | 28,294,758.00 | 32,729,861.20 |
| 110 | Орлогын албан татвар | | 22,434,651.70 | 27,076,473.00 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | | 9,068,467.10 | 12,265,927.60 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | | -450,203.30 | -581,981.30 |
| 1103 | ААН-ын орлогын албан татвар | | 13,816,388.00 | 15,392,526.70 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | | 2,385,775.10 | 2,290,998.00 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | | 3,474,331.20 | 3,362,390.30 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | | 310,750.60 | 336,963.70 |
| 1181 | Газрын төлбөр | | 1,113,651.20 | 1,520,991.10 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | | 2,025,512.30 | 1,445,932.90 |
| 1183 | Бусад татвар | | 24,417.00 | 58,502.70 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 42,411,453.10 | 54,123,121.40 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 23,811,515.10 | 27,259,203.80 |
| 121 | Хөрөнгийн орлого | | 73,616.60 | 103,876.60 |
| 122 | Тусламжийн орлого | | 3,000.00 | 0 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | | 18,523,321.40 | 26,760,041.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 23,455,510.70 | 31,654,770.70 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 49,649,674.60 | 58,818,781.70 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 49,649,674.60 | 58,818,781.70 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 48,187,443.10 | 57,869,552.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 12,481,811.70 | 16,561,757.60 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 2,151,448.00 | 2,824,669.20 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 6,939,014.70 | 2,214,763.40 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 7,733,978.00 | 5,783,600.30 |
| 2105 | Нормативт зардал | | 379,090.50 | 12,171.30 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 1,152,363.80 | 518,010.80 |
| 2107 | Томилот, зочны зардал | | 243,586.40 | 341,033.10 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 7,365,496.50 | 13,781,887.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 9,740,653.40 | 15,831,659.40 |

| | | | | |
|------|--|--|----------------|----------------|
| 212 | ТАТААС | | 330,000.00 | 70,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 1,132,231.50 | 879,229.70 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | | 44,512,047.10 | 59,688,971.70 |
| IV | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV) | | 15,346.40 | 9,588.90 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | | 40,990,490.40 | 48,341,459.90 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 40,990,490.40 | 48,341,459.90 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | | 40,990,490.40 | 48,341,459.90 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | | -40,975,144.00 | -48,331,871.00 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | | -4,864,725.20 | -1,442,669.40 |
| 14 | Бусад эх үүсвэр | | 15,154.40 | 47,291.80 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | | 4,855,146.70 | 1,439,736.90 |
| 25 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | | 24,732.90 | 50,224.40 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | | -1,327,822.00 | 9,914,431.30 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 16,144,818.80 | 14,816,996.80 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 14,816,996.80 | 24,731,428.10 |

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү | Хувь |
|------|--|--------------|-----------------------------|--------------|------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 84,944,730.0 | 61,253,255.4 | 23,691,474.6 | 72 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 47,044,209.8 | 41,509,616.0 | 5,534,593.8 | 88 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 45,189,173.1 | 39,872,710.9 | 5,316,462.2 | 88 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 11,602,022.9 | 11,145,384.4 | 456,638.5 | 96 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,440,223.9 | 1,368,845.7 | 71,378.2 | 95 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 6,908,039.8 | 6,277,227.8 | 630,812.0 | 91 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 944,237.3 | 874,778.2 | 69,459.1 | 93 |
| 2105 | Нормативт зардал | 14,600.0 | 3,784.6 | 10,815.4 | 26 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,421,145.2 | 1,376,697.9 | 44,447.3 | 97 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 359,389.2 | 321,185.4 | 38,203.8 | 89 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,994,214.7 | 4,616,924.3 | 377,290.4 | 92 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,505,300.1 | 13,887,882.6 | 3,617,417.5 | 79 |
| 212 | ТАТААС | 1,012,175.3 | 868,439.4 | 143,735.9 | 86 |
| 2121 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 387,233.8 | 387,233.8 | - | 100 |
| 2122 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 624,941.5 | 481,205.6 | 143,735.9 | 77 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 842,861.4 | 768,465.8 | 74,395.6 | 91 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 842,861.4 | 768,465.8 | 74,395.6 | 91 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 35,240,576.7 | 18,631,539.4 | 16,609,037.3 | 53 |

| | | | | | |
|--------|---|--------------|--------------|--------------|-----|
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 2,659,943.5 | 1,112,100.0 | 1,547,843.5 | 42 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 84,944,730.0 | 63,669,545.1 | 21,275,184.9 | 75 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 17,153,750.0 | 16,990,657.4 | 163,092.6 | 99 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 59,333,529.6 | 42,757,012.6 | 16,576,517.0 | 72 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 8,457,450.4 | 3,921,875.1 | 4,535,575.3 | 46 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 3,577,218.8 | | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 6,027,167.2 | | |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 1,025.00 | 937 | 88.00 | 91 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 27 | 27 | 0.00 | 100 |
| 610001 | Төсвийн байгууллага | 27 | 27 | 0.00 | 100 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 499 | 455 | 44.00 | 91 |
| 620001 | Удирдах ажилтан | 115 | 110 | 5.00 | 96 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 247 | 235 | 12.00 | 95 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 114 | 88 | 26.00 | 77 |
| 620004 | Гэрээт ажилтан | 23 | 22 | 1.00 | 96 |

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Код | Үзүүлэлт | /мянган төгрөг/ ТЕЗ цэвэр дүн |
|------|--|----------------------------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,612,449.93 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,612,449.93 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,143,846.53 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 33,856.96 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 3,363.93 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 18,098.18 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 76,415.27 |
| 2105 | Нормативт зардал | 3,587.45 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 57,088.90 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 10,350.40 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,019,955.24 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,921,130.20 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 468,603.40 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 100,706.00 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 367,897.40 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 3,612,449.93 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 3,612,449.93 |
| III | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | 0 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 |

5. АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

5.1 Аудитын зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

Аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагч, аймгийн Засаг дарга М.Идэрбат:

1. Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагаас авах хандив, тусламжийн орлогыг төсвийн нэгтгэсэн дансанд төвлөрүүлж, төсвийн зарлагыг батлуулан зарцуулж хэвших;
2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэсэн 103.0 сая төгрөгийн хөл бөмбөгийн талбайн авто машины зогсоолын данс бүртгэлд тусгаж, хөрөнгийн хадгалалт, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах;
3. Эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын албан ажлын автомашинуудад MNS 4598 стандартад заасан мэдээлэл, хяналтын төхөөрөмж буюу GPS суурилуулах нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах;

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Д.Ариунжаргал:

1. Авлага, өр төлбөрийн тогтмол тооцоо нийлсэн актаар баталгаажуулж санхүүгийн тайланд тусгах;
2. Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэн гаргахтай холбоотойгоор СТСХ-ээс ерөнхий чиглэл боловсруулан нэгдсэн мэдээллээр хангаж, санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлэх, илэрсэн алдаа зөрчлийг нэмэгдүүлэхгүй байх чиглэлээр авах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх;
3. Хоршоо хөгжүүлэх сангийн нэгдсэн байдлаар зохиомжилсон программ хангамжтай болгох асуудлыг судалж, нэвтрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах

5.2. Үндэсний аудитын газарт санал:

Санхүүгийн аудиттай холбоотой дараах саналыг УАГ-ын Санхүү-Нийцлийн аудитын газарт уламжилж байна. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангаас (хуучин нэрээр) зээлд хамрагдсан зарим иргэд гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй, зээлийг хугацаа хэтрүүлсэн асуудлыг шүүхийн байгууллагад шилжүүлж, анхан шатны шүүхийн шийдвэр болон эвлэрүүлэн зуучлахаар гэрээ байгуулсан боловч зээл, зээлийн хүүг өнөөг хүртэл төлөөгүй байна. Ажил хариуцсан албан тушаалтан хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэх ажиллагаа явуулах хүсэлтийг шүүхэд гаргаагүйгээс хөөн хэлэлцэх хугацаа дуусаж, төсвийн хөрөнгө төлөгдөөгүй, үрэгдэх эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн байна. Иймд **зээлээ төлөөгүй байгаа иргэдийн гэрээний үүргийг** хангуулах чиглэлээр **хууль, эрх зүйн орчинд өөрчлөлт оруулж, төсвийг хохиролгүй болгох асуудлыг нэгдсэн журмаар шийдвэрлүүлэх саналыг уламжлуулах хүсэлтэй байна.**
- Тээвэр шатахууны зардлын үр ашгийг дээшлүүлэхэд албан ажлын автомашинуудад MNS 4598 стандартад заасан мэдээлэл, хяналтын

төхөөрөмж буюу GPS суурилуулах нэгдсэн арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах зөвлөмжийг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгуулах саналтай байна. Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлснээр тээвэр шатахууны зарцуулалтын үр ашиг дээшилж, төсөв хэмнэгдэх боломжтой байна.

- Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг илүү төлөвлөж авах нөхцөл байдал илэрсэн. Тухайлбал гүйцэтгэл, үр дүнгээр санхүүждэг төсөвт байгууллагуудын байр ашиглалтын зардал болох тогтмол зардлаас жил бүр төсөв хэмнэгдэн үлдэж байна. Уг хэмнэгдсэн үлдэгдлийг урьд оны үлдэгдлээс санхүүжих төсвийн орлого хэсэгт батлан дараагийн төсвийн жил зарцуулж байна. Иймд санхүүгийн дэмжлэгээс үлдсэн хөрөнгийг хэмнэлтэд тооцож болох эсэх асуудлаар нэгдсэн чиглэл авахыг уламжилж байна.

